МБҮА ТББ НЬ ДОТООДЫН БАРИЛГЫН КОМПАНИУД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ АСУУДЛААР ШАТ ДАРААЛСАН АРГА ХЭМЖЭЭГ АВЧ БАЙНА


МБҮА ТББ нь Монгол Улсын томоохон барилга, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт, зураг төсөл, архитектурын чиглэлийн 200 гаруй барилгын компаниудыг эгнээндээ нэгтгэж, нийгэмдээ болон гишүүддээ үйлчилдэг, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж, тэдний дуу хоолойг төрд хүргэх, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, гүүр болж ажилладаг билээ. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал Сэлбэ дэд төвийн 1, 2-р багцын сонгон шалгаруулалт зарласан цаг үеэс эхлэн Нийслэлийн Засаг даргын тамгын газар албан бичиг хүргүүлж ажиллаж байна.

2024.12.14 ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСЛИЙН НЭГЖИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДЭД АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ ХАМРУУЛАХ ТАЛ ДЭЭР САНАМЖ БИЧИГ ЗУРЛАА

Монгол Улсын Засгийн газраас улс орны өмнө тулгамдсан асуудлыг шийдэх том төслүүдийг эхлүүлнэ гэдгээ мэдэгдэж хөгжлийн гол бүтээн байгуулалт болох 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Тус мега төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг 2025 оны нэгдсэн төсөвт суулган баталсан билээ. Ирэх онд уг мега төслүүд гараанаас хөдөлж эхлэх нь тодорхой болсон энэ цаг үед МБҮА ТББ-ын зүгээс Гишүүн байгууллагуудтайгаа хамтран уг төслүүдэд хэрхэн хамтран ажиллах талаар санал бодлоо солилцох уулзалт боллоо. Уг ажлын хүрээнд Түгжрэлийг бууруулах 6 багц төслүүдийг хэрэгжүүлэхэд төр-хувийн хэвшлийн хамтын үйл ажиллагаа нэн чухал бөгөөд үүний тулд гэрээний нөхцөл байдал буюу Фидик гэрээний зарчмаар ажиллахаар санамж бичигт 2025.12.14-нд гарын үсэг зурлаа.

2025.04.12 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАРТАЙ УУЛЗАЛТ ХИЙВ

Олон улсын геополитик, худалдааны дайн нь хөрш орны болон Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд муугаар нөлөөлж байгаа энэ цаг үед дотоодын барилгын салбарын ААН, компаниудыг дэмжих бодлого нэн шаардлагатай байгаа төдийгүй 2025-2028 онд нийслэлд хэрэгжих Сэлбэ дэд төв, Туул хурдны зам зэрэг барилга бүтээн байгуулалтын төслүүдэд дотоодын барилгын компаниудад Ерөнхий гүйцэтгэгчээр оролцох боломжийг бүрдүүлж, тухайн ажлуудыг хэсэгчлэн хуваан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, өөрчлөх талаар МБҮА ТББ-ын удирдлагууд Гишүүн компаниуд, салбарын төрийн бус байгууллагуудын хамт шат дараалсан уулзалтуудыг хийж Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн Гүйцэтгэх захирал У.Баатар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч Агентлаг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Батцэцэг, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Амгалан нарт албан хүсэлт өгөөд байна.



МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТӨБ
Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг,
3 дугаар хороо, Сансрын гудамж 24, МБҮ Төрөө,
8-р давхар, 805, 806, 811 тоот, Утас: + (976) 7011 1313
Утас: + (976) 7010 5055, + (976) 7010 5055
И-мэйл: info@mbca.mn, Вэб: www.mbca.mn

СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ
КОРПОРАЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ У.БААТАР ТАНАА

2025.05.28 № 29/ТВАА

Танай _____-ны №_____-т

Хүсэлт хүргүүлэх тухай


Монгол Улсын шинэ цагийн барилын салбар үүсэж хөгжөөд 100 жил болох гэж байна. Ут хугацаанд үндэсний барилын компаниуд адийн засилийн хөгжлөө даган өсөж хөгжөөд байгаа бөгөөд уул уурхай, банк, санхүү зэрэг Монгол Улсад хөгжлөөрөө тэргүүлэх байгаа салбарууддын нэгд зүй ёсоор тооцогдох бөгөө.

Хэдийгээр асаж хөгжиж байгаа ч үндэсний барилын компаниуд Нийслэлийн Засаг даргын харьяа нутаг дэвсгэрт Худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу зарлах бүй зарим тендер шалгаруулалтын шаардлагад нийцэхэд санхүүгийн хүнд хүндрэлтэй байна. Үүний шалтгаан нь адийн засаг, цаг тахал гэх мэт гадаад хүчин зүйлсээс шалтгаалан барилуулалтын орлогын хэмжээ тогтвортой бус, мөн Монгол Улс дахь санхүүгийн зардал, хүүгийн түвшин өндөр байгаагаас бизнесийн байгуулагууд тургэн хөрөөх чадвартай хөрөнгийг тодийлөн өндөр түвшинд байлгадагүйтэй холбоотой юм. Жишээлбэл Нийслэлийн худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу Сэлбэ дэд төвийн орон сууцны их бүрэн цогцолбор хороолол тендерүүдийн тээвэт ертөг өндөр байх бөгөөд үүнтэй уялдуулан гаргасан санхүүгийн чадвахын шаардлага болох сүүлийн 3 жилийн барилуулалтын орлогын нийлбэр хэмжээ болон тургэн хөрөөх хөрөнгийн хэмжээ нь батлагдсан тээвэт ертөгийн 20 хувиас багагүй байна гэсэн шаардлага нь хэт өндөр байна гэж үзэж байна.

Ут нөхцөл, шаардлагуудаас шалтгаалан гадаадын компаниудад давуу нөхцөл бүрдэж, үндэсний компаниудын оролцоо хязгаарлагдаж байна. Үндэсний барилын компаниудын санхүүгийн чадвахыг унагах, түүнд нийцсэн тендер шалгаруулалт зохиож, үндэсний барилын компаниудыг улсынхаа бүтээн байгуулалтын ажилд оролцуулах боломжийг бүрдүүлэх нь нэг талаараа компаниудыг санхүүгийн болоод ур чадварын хувьд чадвахжуулах, нөгөө талаарааа гадаашлах явцтын үрсэлыг дотоддоо үлдээх боломжийг олгох юм.

Иймд Сэлбэ дэд төвийн орон сууцны их бүрэн цогцолбор хороолол тендер шалгаруулалтуудад дараах өөрчлөлтүүдийг оруулж, үндэсний компаниудын оролцоог нэмэгдүүлж өгнө үү. Үүнд:

1. Багц тус бүрийг барилга угсралтын ажлын хуваарилалтын боломжийг харгалзан 6-8 хэсэг болгон хуваан, нийт тээвэт ертөгийг 80 тэрбум төгрөгөөс ихгүй болгож бүрдүүлэх;
2. Барилуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилийн барилуулалтын орлогын нийлбэр хэмжээ нь батлагдсан тээвэт ертөгийн 20 хувиас багагүй байх шаардлагыг 5 хувь хүртэл бууруулах;



3. Тургэн хөрөөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан тээвэт ертөгийн 20 хувиас багагүй байх шаардлагыг 5 хувь хүртэл бууруулах.

Манай байгууллага нь Тер-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, үнэдааг сайжруулах, үйл ажиллагаг зохион байгуулах, оролцогч талууд зөлөлдөн нэгдэж, хамтран ажиглах нөхцөл болоцоог бүрдүүлэх зорилго тавин ажилладаг бөгөөд энэхүү зорилтын хүрээнд Монгол Улсын үндэсний барилын компаниудын чадамжид нийцүүлэн дээр дурдсан өөрчлөлтүүдийн хүсэлтийг гаргаж байгаад хүлээн авч, холбогдох журмын дагуу шийдвэрлэж өгнө гэдэгт итгэлтэй байна.

ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРСАЙХАН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР


2025.05.12 НИЙСЛЭЛИЙН 1-Р ОРЛОГЧ Т.ДАВААДАЛАЙ, СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ КОРПОРАЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ У.БААТАР БОЛООД ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН НЭГЖТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ ХИЙВ

2025.05.16 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ДОТООДЫН КОМПАНИУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР НИЙСЛЭЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО

2025.05.22 СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ТЕНДЕРТ МОНГОЛ КОМПАНИ ОРОЛЦОХ БОЛОМЖГҮЙ АСУУДЛААР ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ГОМДОЛ ГАРГАЛАА

2025.05.28 ТӨРИЙН ОРДНЫ ГАДНА СУУЛТ ХИЙЖ БУЙ БАРИЛГАЧДЫН ЖАГСААЛТ

2025.05.28 МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ, УИХ-ЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН НАРТ АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛЭВ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА


ШААРДЛАГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

2025-05-26 **Улаанбаатар хот**

Таны амар амгаланг эрэн мэндчилье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4-т "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэж тунхагласан билээ. Түүнчлэн "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт "Хотын засаглалд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх, хувийн хэвшлээс нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ" гэж заасан; "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.3.2.5-д "...аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх бодлого баримтална"; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.3.1-т "Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн төлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна" гэсэн бол "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.4.2.1-д "Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ" гэж барилга дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дэмжихээр тусгасан байдаг. Нөгөөтэйгүүр, "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийн 2.3.4.2-т "зах зээлийн харилцаанд нийцүүлэн үндэсний бүтээн байгуулалтын чадавхыг нэмэгдүүлэх, дэмжих, салбарын эдийн засгийн дархлааг бэхжүүлэх, хамгаалах" гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн боловч **эдгээр бодлогын заалтууд бодит амьдралд биеллээ олдоогүй, цаасан дээрх тунхаглал болон** үлдэж байгаад барилгын салбарынхан бид харамсаж байна.

Барилгын салбар нь Монгол Улсын дэд бүтцийн хөгжил, нийгмийн хэрэгцээг хангах, ажлын байр бий болгоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг, ажиллах хүчний шингээлт сайтай эдийн засгийн тэргүүлэх чухал салбаруудын нэг юм. Бид дэлхий нийтийг хамарсан цар



дэмжих бодлого нэн шаардлагатай байгааг Танд сонордуулан дараах **ШААРДЛАГЫГ** уламжилж байна. Үүнд:

1. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан "Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол"-ын тендэрийн 1, 2 дугаар багцуудын сонгон шалгаруулалтыг эргэн харах
2. Энэхүү тендэрийн 3, 4 дүгээр багцыг түдгэлзүүлэх, цуцлах – тендэрийг зарлахдаа өндөр дүнгээр биш 150 орчим тэрбумаар нь хэсэгчлэн хуваах, сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн дотоодын барилгын компаниуд оролцох боломж бүрдүүлэн зарлах
3. Холбогдох хууль тогтоомж (татварын багц хуулиуд, тор, хувийн хэвшлийн түншлэлийн хууль, тендэрийн хууль гм)-д яаралтай өөрчлөлт оруулж үндэсний бүтээн байгуулагчид компаниудаа дэмжсэн шийдвэр гаргах.

Бид энэ асуудлаар ажил хэргийн уулзалт зохион байгуулж гарц шийдлийг гарган хамтран ажиллахад бэлэн байна.

Монголын барилгачид, барилгын салбарын аж ахуйн нэгжүүд бид барилгын салбараа хамгаалж, ажилчдаа ажилтай орлоготой байлгах, салбараа хогжүүлж, зах зээлээ хамгаалан, сүүлийн жилүүдэл үүсээд буй хүндрэлийг даван туулахын төлөөх энэхүү хууль ёсны **ШААРДЛАГЫГ** шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхгүй бол тэмцлийн бусад хэлбэрт үндэсний сонгон түүштай тэмцэх болно.

МОНГОЛЫН БАРИЛГЫН ЭРДЭСИЙН АССОЦИАЦИ ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ..... Н.БАЯРСАЙХАН

МОНГОЛЫН БАРИЛГЫН ИНЖЕНЕР ГЕОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ..... Л.ГАНЗОРИГ

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮЙЛЧЛЭГЧ ЗӨВЛӨХ ҮЙЛДВЭРҮҮДЭЭГҮЙ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ..... Ц.ЭРДЭНЭБАТ

ОРГОН ТЭЭВЭРЛЭХ МАШИН ТОХООРУЛАХ ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ..... Л.СОДНОМДАРЖАА


МОНГОЛЫН БЕТОНЫ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ..... С.УУГАНБАЯР

БАРИЛГЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Э.УУГАНЖАРГАЛ

МОНГОЛЫН ЦОНХ ХАЛАГА ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ..... С.ГАНЗОРИГ

МОНГОЛЫН ИНЖЕНЕРИЙН БОЛОН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ..... Б.БАЛСАНСҮРЭН

МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ..... М.ТҮМЭНЖАРГАЛ



ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ БАРИЛГАЧДЫН НЭГДЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Э.ХИШИГСҮРЭН

БАРИЛГЫН ЗӨВЛӨХ МЭРГЭЖЛИЙН, ЭКСПЕРТҮҮДИЙН "ШИНЭЧЛЭЛ" ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ..... Л.ШАГДАРРАГЧАА

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ..... Ч.НАРАНБААТАР

МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБООНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ ..... Л.МӨНХСАЙХАН

МОНГОЛЫН НИЙГЭМ АХУЙН БАРИЛГЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Э.ТЭМҮҮЖИН

БАРИЛГЫН ТӨСӨВЧДИЙН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ..... У.БАНДИ


БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ТЭРГҮҮН ..... Г.МЯГМАР

2025.05.24 ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ӨРГӨДӨЛ ГАРГАВ

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын бүтээн байгуулалтын тендерт ганц ч Монгол компани оролцох боломжгүй нөхцөл тавиад хуулийн дагуу 2025.05.30-ны өдрийн дотор бүрдүүл гэх шаардлага тавьж байгаа нь техник өгөгдлийн буюу тендерийн худалдах авах ажиллагааны баримт бичигт сүүлийн таван жилийн борлуулалтын орлогоос аль нэг жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх гэсэн өндөр босго тавьсан байна. Тухайлбал Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын төсөвт өртөг нь нийтдээ 840 тэрбум төгрөг, багц болгож хуваасан хэдий ч хоёрдугаар багц нь л гэхэд жилийн 136 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байхыг шаарджээ. Өнөөдрийн нөхцөлд Монгол Улсад ийм хэмжээний орлоготой хувийн компани маш ховор. Нөгөө талаас энэ нь Монгол Улсын хуулийн этгээд, аж ахуй нэгж ажилтай, орлоготой байхын эсрэг зохицуулалт болж байна. Өөрөөр хэлбэл ийм хэмжээний төсөв, өртгийн боломжийг тендер зарласнаас 5 сарын дотор материалаа бүрдүүлж өгнө гэдэг бол Монгол Улсын Хуулийн этгээдийн хувьд асар хүндрэлтэй юм. Уг нөхцөл шаардлагаас шалтгаалан гадаадын компаниудад давуу нөхцөл бүрдэж, дотоодын эдийн засаг, үндэсний компаниудын оролцоо хязгаарлагдаж,

улсын эдийн засгийн хяналт, аюулгүй байдал алдагдах эрсдэл бий болоод байна. Энэ нь Үндсэн хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг зөрчиж байгаа талаар иргэн Г.Батсүх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд өргөдөл гаргаснаа хүлээлгэн өглөө.

2025.06.03 ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ҮҮСГЭХЭЭР БОЛЛОО



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ГИШҮҮНИЙ ТОГТООЛ

2025 оны 06 сарын 02 өдөр Дугаар 82 Улаанбаатар хот

Мэдээллийн зарим шаардлагаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгах тухай

Нэг. Иргэн Б.Раднаасүрэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 1, 2, Тавин наймдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоолгох шаардлага бүхий мэдээлэл ирүүлж холбогдох тайлбар, үндэслэлийг тусгасан байна.

Хоёр. Иргэн Б.Бямба-Оюун Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 1, 2, Тавин наймдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоолгох шаардлага бүхий мэдээлэл ирүүлж холбогдох тайлбар, үндэслэлийг тусгажээ.

Гурав. Иргэн Г.Батсүх Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийг зөрчсөн эсэхийг тогтоолгох шаардлага бүхий мэдээлэл ирүүлж холбогдох тайлбар үндэслэлийг тусгасан байна.


ҮНДЭСЛЭЛ:

1.Иргэн Б.Раднаасүрэн, Б.Бямба-Оюун, Г.Батсүх нарын мэдээллээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн Дунд суудлын хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлтэй байна.

2.Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн иргэн Б.Раднаасүрэн, Б.Бямба-Оюун, Г.Батсүх нарын мэдээллийн шаардлага адил агуулгатай буюу нэг асуудлаар хандсан байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад "нэг асуудлаар хоёр буюу хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт байгаа бол тэдгээрийг нэгтгэх, ..." гэж заасны дагуу нэгтгэн шалгах шийдвэрлэх үндэслэлтэй байна.

3.Иргэн Б.Раднаасүрэн, Б.Бямба-Оюун нар мэдээлэлдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн

1702305212



2

22.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, 2, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн хэмээн дурдсан боловч ямар үндэслэлээр эдгээр заалтыг зөрчсөн болохыг уялдаа холбоотойгоор тодорхой тусгаагүй байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5 дахь заалтад заасан шаардлагыг хангаагүй гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд тус шаардлагаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтыг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1.Иргэн Б.Раднаасүрэн, Б.Бямба-Оюун, Г.Батсүх нарын мэдээллийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;", 13.1.2 дахь заалтад "энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсүгэй.

2.Иргэн Б.Раднаасүрэн, Б.Бямба-Оюун, Г.Батсүх нарын маргааныг нэгтгэн шалгасугай.


3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, 2, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсугай.

4.Хуралдааны бэлтгэл ажиллагаг хангахыг гишүүний туслах А.Тэмүжинд даалгасугай.

ГИШҮҮН Ц.ЦОЛМОН

СЭЛБЭ ДЭД ТӨВ-ийн тендерийг цуцалж дахин тендер зарлахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт саад болж байсан учир 2025.05.22-ны өдөр ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД өргөдөл гаргасан асуудлыг Үндсэн хуулийн цэцээс хянаж үзээд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;", 13.1.2 дахь заалтад "энэ хуулиин 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл арга, хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1, Долдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсүгэй хэмээн үзэж уг асуудлыг Үндсэн хуулийн дунд суудлын цэц шалган шийдвэрлэхээр боллоо.

2025.06.09 МОНПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР АЛБАН ХҮСЭЛТ ӨГӨВ



МБҮА

МОНГОЛ БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
Монгол Улс, Улаанбаатар 13141, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Самбуугийн гудамж 24, МН Тауэр,
8-р давхар, 803, 808, 811 тоот, Утас: + (976) 7011 1515
Утас: + (976) 7016 5055, + (976) 7018 5055
И-мэйл: info@mnca.mn, Веб: www.mnca.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ МОНОПОЛИЙН
ЭСРЭГ ГАЗАР-т

_____2025.06.09_____№_____25/86/АА_____


Танай _____-ны №_____-т

Гомдол гаргах тухай

Манай байгууллага нь 2009 оноос хойш барилгын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж буй бөгөөд эгнээндээ 200 орчим аж ахуйн нэгжийг нэгтгэн 2018 оноос төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа барилгын салбарын тэргүүлэх төрийн бус байгууллага билээ.
Салбарын болон пишүүн аж ахуйн нэгжүүдийнхээ эрх ашгийг хамгаалах тодний дуу хоолойг олон нийт, төрийн байгууллагад хүргэх үндсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын барилгын аж ахуйн нэгжүүд нь сүүлийн 30 жилийн хугацаанд барилга орон сууц, үл хөдлөхийн томоохон төслүүдийг амжилттай хийж гүйцэтгэж ирсэн бөгөөд барилга орон сууцны төслүүдийг гүйцэтгэх хүн хүч, технологи, төслийн удирдлагын бүрэн чадамжтай боловч нийслэлийн худалдан авах ажиллагааны гаэрас зарласан "Сэлбэ дэд тевийн орон сууцны их бүрэн цогцолбор хороолол"-ын энгийн дунд төвөгшилтэй 9-12 давхар орон сууцны барилга угсралтын тендерт монголын барилгын нэг ч компани оролцох нөхцөл боломж байсангүй. Үчир нь тус тендерийг 2 ye шатгай 4 багц болгон зарлаж байгаа бөгөөд ахний 1, 2 дугаар багцыг хэт өндөр дүнтэй буюу 1 дүгээр багц 373.6 тэрбум төгрөг, 2 дугаар багц 453.5 тэрбум төгрөгийн үнэтэй зарлаж, тендерт оролцогчод тавьсан санхүүгийн шалгуур хэт өндөр байснаас нийт 827.1 тэрбум төгрөгийн ажлыг Монгол компанид гүйцэтгэх боломж алдагдаж байна. Иймхүү хөрөнгө оруулалтын үлэмжхэн хувийг гадныи аж ахуйн нэгжүүдад гүйцэтгэх болж барилгын дотоодын зах зээлээ бусдад алдах нөхцөл байдал үүслээ. Бид дээрх асуудлаар холбогдох байгууллагуудад албан хүсэлт, саналуудаа удаа дараа хүргүүлж, уулзаж ирсэн. Гэтэл уг тендерийн 3, 4 дэх багцуудыг 2025 оны 05 сарын 09-нд мөн зарласан хадий ч үнийн дүн нь 3 дугаар багц 616.6 тэрбум төгрөг, 4 дугаар багц 491.1 тэрбум төгрөг болгож, өмнөх хоёр багцаас бүр илүү өндөрсөн нь илтэд гадныи аж ахуйн нэгжийг дэмжсэн, шударга өрсөлдөөнийг хязгаарласан гэж бид үзэж байна.

Дээрх байдлаар сонгон шалгаруулалтыг зарласан нь Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.5 дэх заалтын болон техникийн бодит үндэслэлгүйгээр аж ахуйн бусад харилцаа тогтоохоос татгалзах, үндэслэлгүйгээр шалгуур үзүүлэлт тогтоох, 11.1.4 уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, түүний нэг багц, хэсэгт харилцан хамаарал бүхий этгээдтэй хамт оролцох, эсхүл бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулах, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох, 13.2.3.тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн, 13.2.5.зах зээлийг



нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн үйлдэл тус тус боллоо.

Иймд дээрх нийслэлийн худалдан авах ажиллагааны гаэрас зарласан "Сэлбэ дэд тевийн орон сууцны их бүрэн цогцолбор хороолол"-ын багц 3, НХААГ/20250101646, багц 4, НХААГ/20250101647 тендер сонгон шалгаруулалтын Өрсөлдөөний тухай хууль зөрчөөнийг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгнө үү.

Хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г. БАТСУХ